

ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Говь-Алтай аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ГАА-2022/01/-НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Говь-Алтай аймаг Алтай хот 2021 он	Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газрын дарга Дарга, Тэргүүлэх аудитор: Х.Түвшинбаяр Утас: 70483413 Цахим хаяг: tuvshinbayarkh@audit.gov.mn Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг Утас:70484055 Цахим хаяг: erdenechimegd@audit.gov.mn Ахлах аудитор: Ж.Бүжинханд Утас: 70484030 Цахим хаяг: Bujinkhandj@audit.gov.mn
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт	2
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	4
3. Аудитын тайлан	8
3.1 Ерөнхий зүйл	8
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	9
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	9
3.4 Материаллаг байдал	10
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	10
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	10
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	11
3.8 Аудитын гол асуудал	11
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	11
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	12
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	12
4. Аудитын илрүүлэлт	12
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	14

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ТШЗ	Төсвийн шууд захирагч
НА	Нийцлийн аудит



ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

9018301, Говь-Алтай аймаг,
Есөнбулаг сум, 7-р баг, Жинст 0
Утас: 70-48-34-13. Факс: (976) 70-48-34-13,
E-mail: govialtai@audit.gov.mn

2022.03.02 № 152

танай _____ -ны № _____ -т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Говь-Алтай аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Говь-Алтай аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Татварын тодорхойлолтоор өглөг, авлага зөрүүтэй, авлага, өглөгийг барагдуулаагүй, жолоочийн тооцоо, зарцуулалтын тайлангүй шатахуун зарцуулсан, шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг байршуулаагүй зэрэг материаллаг 21.3 сая төгрөгийн зөрчил нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Шилэн дансны тухай хуулийн холбогдох заалттай, АДБОУС 1250, 1300, MNS-6817-4:2020 стандартын 7.1.2.2, 7.1.3.4 заалттай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

07000010

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Х.ТҮВШИНБАЯР



2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан /төгрөг/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	37,374,274.90	77,530,219.96
33	АВЛАГА	30,958,074.90	49,478,557.96
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	142,634.90	247,925.96
33500	Бусад авлага	30,815,440.00	49,230,632.00
33510	Байгууллагаас авах авлага	0	18,415,192.00
33520	Хувь хүмүүсээс авах авлага	30,815,440.00	30,815,440.00
34	УРЬДЧИЛГАА	11,372.00	11,372.00
34710	Урьдчилгаа тооцоо	11,372.00	11,372.00
34713	Цалингийн урьдчилгаа	11,372.00	11,372.00
35	БАРАА МАТЕРИАЛ	6,404,828.00	28,040,290.00
35400	Хангамжийн материал	6,404,828.00	28,040,290.00
35410	Бичиг хэргийн материал	321,000.00	105,000.00
35420	Аж ахуйн материал	2,917,890.00	27,935,290.00
35440	Түлш, шатах тослох материал	3,111,238.00	0
35470	Бусад хангамжийн материал	54,700.00	0
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	133,892,802.83	123,048,561.24
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	133,892,802.83	123,048,561.24
39200	Биет хөрөнгө	133,672,802.83	122,918,561.24
39203	Авто-тээврийн хэрэгсэл	168,000,000.00	145,000,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-87,513,888.84	-90,625,000.20
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	41,145,038.00	61,884,628.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-10,535,083.40	-19,713,875.21
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	40,285,960.00	50,245,960.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-17,709,222.93	-23,873,151.35
39300	Биет бус хөрөнгө	220,000.00	130,000.00
39301	Програм хангамж	750,000.00	750,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-530,000.00	-620,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	171,267,077.73	200,578,781.20
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	171,267,077.73	200,578,781.20
51	Засгийн газрын хувь оролцоо	171,267,077.73	200,578,781.20
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	122,211,354.00	122,211,354.00
51200	Хуримтлагдсан үр дүн	46,459,614.90	75,771,318.37
51210	Өмнөх үеийн үр дүн	28,140,924.22	46,459,614.90
51220	Тайлант үеийн үр дүн	18,318,690.68	29,311,703.47
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	2,596,108.83	2,596,108.83
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	171,267,077.73	200,578,781.20

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан /төгрөг/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	745,270,000.00	1,090,190,400.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	10,795,000.00	1,500,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	10,795,000.00	1,500,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	10,795,000.00	0
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	10,795,000.00	0
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	0	1,500,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	734,475,000.00	1,088,690,400.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	160,200,000.00	153,290,000.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	200,000.00	0
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	160,000,000.00	153,290,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	574,275,000.00	935,400,400.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	574,275,000.00	935,400,400.00

Говь-Алтай аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	726,870,809.49	1,055,281,474.05
21	УРСГАЛ ЗАРДАЛ	726,870,809.49	1,055,281,474.05
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	464,308,192.02	949,900,528.05
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	166,544,118.86	201,018,716.00
210101	Үндсэн цалин	128,642,001.06	143,526,656.00
210102	Нэмэгдэл	18,747,248.00	32,182,883.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	12,546,274.80	16,900,000.00
210104	Урамшуулал	6,608,595.00	8,409,177.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	21,282,015.00	26,387,649.94
210201	Тэтгэврийн даатгал	14,859,665.98	18,365,528.80
210202	Тэтгэмжийн даатгал	1,218,811.26	2,030,943.55
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,392,613.45	1,626,864.57
210204	Ажилгүйдлийн даатгал	509,405.85	405,372.98
210205	Эрүүл мэндийн даатгал	3,301,518.46	3,958,940.04
2104	Хангамж, бараа материалын зардал	22,200,675.00	29,508,256.00
210401	Бичиг хэрэг	4,326,500.00	3,622,650.00
210402	Тээвэр, шатахуун	15,263,168.00	20,597,652.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,043,057.00	2,892,054.00
210404	Ном, хэвлэл	567,950.00	2,395,900.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	17,777,000.00	38,945,000.00
210604	Урсгал засвар	17,777,000.00	38,945,000.00
2107	Томилолт, зочны зардал	2,073,200.00	4,931,550.00
210702	Дотоод албан томилолт	2,073,200.00	4,931,550.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	179,646,958.77	129,137,928.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	172,900,650.77	123,744,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	577,800.00	0
210803	Даатгалын үйлчилгээ	3,799,660.00	3,792,355.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	248,248.00	321,573.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	44,000.00	0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,076,600.00	1,280,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	54,784,224.39	519,971,428.11
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	13,071,548.00	445,975,669.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	13,980,420.00	36,549,150.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	27,732,256.39	37,446,609.11
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	262,562,617.47	105,380,946.00
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	252,500,000.00	0
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	252,500,000.00	0
2132	Бусад урсгал шилжүүлэг	6,991,654.00	6,980,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	6,991,654.00	6,980,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	3,070,963.47	98,400,946.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,070,963.47	98,400,946.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	18,399,190.51	34,908,925.95
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	80,499.83	5,597,222.48
225001	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз	80,499.83	5,597,222.48
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	18,318,690.68	29,311,703.47

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан /төгрөг/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
1	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	122,211,354.00	2,596,108.83	38,279,310.22	163,086,773.05
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0	0	-10,138,386.00	-10,138,386.00
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	122,211,354.00	2,596,108.83	28,140,924.22	152,948,387.05
9	Тайлант үеийн үр дүн	0	0	18,318,690.68	18,318,690.68
10	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	122,211,354.00	2,596,108.83	46,459,614.90	171,267,077.73
11	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	122,211,354.00	2,596,108.83	46,459,614.90	171,267,077.73
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	122,211,354.00	2,596,108.83	46,459,614.90	171,267,077.73
19	Тайлант үеийн үр дүн	0	0	29,311,703.47	29,311,703.47
20	2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	122,211,354.00	2,596,108.83	75,771,318.37	200,578,781.20

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан /төгрөг/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	734,475,000.00	1,088,690,400.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	734,475,000.00	1,088,690,400.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	160,200,000.00	153,290,000.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	200,000.00	0
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	160,000,000.00	153,290,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	574,275,000.00	935,400,400.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	574,275,000.00	935,400,400.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	701,281,654.00	1,057,990,810.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	701,281,654.00	1,057,990,810.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	438,719,036.53	936,250,238.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	166,463,371.76	201,018,716.00
210101	Үндсэн цалин	128,609,085.68	143,526,656.00
210102	Нэмэгдэл	18,699,416.28	32,182,883.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	12,546,274.80	16,900,000.00
210104	Урамшуулал	6,608,595.00	8,409,177.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	21,282,015.00	26,492,941.00
210201	Тэтгэврийн даатгал	14,859,665.98	18,365,528.80
210202	Тэтгэмжийн даатгал	1,218,811.26	2,030,943.55
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,392,613.45	1,626,864.57
210204	Ажилгүйдлийн даатгал	509,405.85	405,372.98
210205	Эрүүл мэндийн даатгал	3,301,518.46	4,064,231.10
2104	Хангамж, бараа материалын зардал	23,934,507.00	28,130,934.00
210401	Бичиг хэрэг	4,323,500.00	3,301,000.00
210402	Тээвэр, шатахуун	17,000,000.00	19,541,980.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,043,057.00	2,892,054.00
210404	Ном, хэвлэл	567,950.00	2,395,900.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	17,901,190.00	63,203,400.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	124,190.00	24,258,400.00
210604	Урсгал засвар	17,777,000.00	38,945,000.00
2107	Томилот, зочны зардал	2,073,200.00	4,931,550.00
210702	Дотоод албан томилот	2,073,200.00	4,931,550.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	179,575,636.77	129,137,928.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	172,829,328.77	123,744,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	577,800.00	0

210803	Даатгалын үйлчилгээ	3,799,660.00	3,792,355.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	248,248.00	321,573.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	44,000.00	0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,076,600.00	1,280,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	27,489,116.00	483,334,769.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	13,537,496.00	446,734,669.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	13,951,620.00	36,600,100.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	262,562,617.47	121,740,572.00
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	252,500,000.00	0
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	252,500,000.00	0
2132	Бусад урсгал шилжүүлэг	6,991,654.00	23,339,626.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	0	16,359,626.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	6,991,654.00	6,980,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	3,070,963.47	98,400,946.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,070,963.47	98,400,946.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	33,193,346.00	30,699,590.00
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	33,195,000.00	30,699,590.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	33,195,000.00	30,699,590.00
2200	Дотоод эх үүсвэрээр	33,195,000.00	30,699,590.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	33,195,000.00	30,699,590.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-33,195,000.00	-30,699,590.00

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан /төгрөг/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	935,400,400.00	836,999,454.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	935,400,400.00	836,999,454.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	912,040,700.00	813,659,828.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	218,667,700.00	201,018,716.00
210101	Үндсэн цалин	195,567,700.00	143,526,656.00
210102	Нэмэгдэл	0	32,182,883.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	23,100,000.00	16,900,000.00
210104	Урамшуулал	0	8,409,177.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	30,382,800.00	26,492,941.00
210201	Тэтгэврийн даатгал	20,500,000.00	18,365,528.80
210202	Тэтгэмжийн даатгал	2,470,700.00	2,030,943.55
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,976,600.00	1,626,864.57
210204	Ажилгүйдлийн даатгал	494,100.00	405,372.98
210205	Эрүүл мэндийн даатгал	4,941,400.00	4,064,231.10
2104	Хангамж, бараа материалын зардал	26,596,200.00	25,930,934.00
210401	Бичиг хэрэг	2,801,800.00	2,801,000.00
210402	Тээвэр, шатахуун	17,842,600.00	17,841,980.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,551,800.00	2,892,054.00
210404	Ном, хэвлэл	2,400,000.00	2,395,900.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	144,945,000.00	93,902,990.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	95,500,000.00	44,997,990.00
210602	Тавилга	10,000,000.00	9,960,000.00
210604	Урсгал засвар	39,445,000.00	38,945,000.00
2107	Томилолт, зочны зардал	5,000,000.00	4,931,550.00
210701	Гадаад албан томилолт	0	0
210702	Дотоод албан томилолт	5,000,000.00	4,931,550.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,449,000.00	5,437,928.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,000,000.00	44,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	3,800,000.00	3,792,355.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	325,000.00	321,573.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	44,000.00	0

210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,280,000.00	1,280,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	480,000,000.00	455,944,769.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	467,600,000.00	444,109,669.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	12,400,000.00	11,835,100.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	23,359,700.00	23,339,626.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	23,359,700.00	23,339,626.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	16,359,700.00	16,359,626.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	7,000,000.00	6,980,000.00
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	935,400,400.00	836,999,454.00
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	935,400,400.00	836,999,454.00
320001	Орон нутгийн төсвөөс	935,400,400.00	836,999,454.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан /төгрөг/

Код	Үзүүлэлт	ТАЙЛАНТ ОН
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	153,290,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	153,290,000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	153,290,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	2,200,000.00
210401	Бичиг хэрэг	500,000.00
210402	Тээвэр, шатахуун	1,700,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	123,700,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	123,700,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	23,790,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,625,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	24,765,000.00
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	153,290,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	153,290,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	153,290,000.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Говь-Алтай аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангах, татварын байгууллагатай тооцоо нийлж санхүүгийн тайланг бодитой үнэн зөв хөтлөхтэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Ж.Бүжинханд гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Д.Эрдэнэчимэг, дарга, тэргүүлэх аудитор Х.Түвшинбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Говь-Алтай аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дугаар сарын 24-ны өдрийн 1/13 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 02 дугаар сарын 14-нийн өдрийн 1/27 тоот албан бичгээр нягтлан бодогч ковид цар тахлын улмаас санхүүгийн тайланг хуулийн хугацаанд нь шалгуулах боломжгүй эрсдэл үүссэн тул нөхцөл байдлыг харгалзан аудитын хугацааг сунгах хүсэлт ирүүлсэн. Үүний дагуу аудитыг 2022 оны 02 дугаар сарын 28-ны өдрөөс 2022 оны 03 дугаар сарын 01-ний өдрийн хооронд гүйцэтгэсэн болно.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Говь-Алтай аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын ээлжит хуралдаануудыг тогтсон хугацаанд зарлан хуралдуулж, хамт олны оролцоог нэмэгдүүлэх зарчмыг баримталж, төрийн үйлчилгээг иргэдэд ойртуулан, нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагыг төлөвшүүлэн хөгжүүлэх, нутгийн удирдлагын тогтолцоог боловсронгуй болгож, хуралдаанаас батлагдсан хөтөлбөрт тусгагдсан асуудлуудыг бүрэн ханган биелүүлэн, төрийн хууль тогтоомжийг иргэдэд хүргэж, хуулийн өөрийн шийдвэрийн хэрэгжилт, аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, нийгэм эдийн засгийн үндсэн чиглэлийн биелэлтэд хяналт тавьдаг орон нутгийн байгууллага юм.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт өөрчлөлт орсон байна.

Коронавируст халдварт /Ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийг 2020 онд баталсан. Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолд төсвийн хөрөнгийг үр ашигтай зарцуулж, төсөвт зардлыг хэмнэхэд чиглэсэн 9 арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг эрүүл мэнд, онцгой байдал, мэргэжлийн хяналт, гааль болон төрийн чиг үүргийн байгууллагаас бусад байгууллагад даалгасан байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуульд шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаарыг шинэчлэн тогтоожээ.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн дэргэдэх Санхүүгийн хяналт аудитын алба нь 2021 онд Говь-Алтай аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын санхүүгийн үйл ажиллагаа, Шилэн дансны хуулийн хэрэгжилтэд дотоод аудит хийгээгүй байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Говь-Алтай аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлаар сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг 2020 оны санхүүгийн тайлангийн нийт зардлын дүн болох 726.8 сая төгрөгөөс 2 хувиар буюу 14.5 сая төгрөгөөр тогтоосон. Гүйцэтгэлийн шатанд 2021 оны санхүүгийн тайлангийн нийт зардал 1,055.3 сая төгрөгөөс 2 хувиар буюу 21.1 сая төгрөгөөр тооцсон. АДБОУС 2320-н 13-д зааснаар санхүүгийн тайланд анхлан тогтоосноос бага материаллаг байдал зохистой тул гүйцэтгэлийн материаллаг байдлыг шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Говь-Алтай аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 17.1 хувиар буюу 29.3 сая төгрөгөөр буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, эздийн өмчийн данс байна.

Авлага дансны эхний үлдэгдэл 30.9 сая төгрөг, тайлант онд 18.5 сая төгрөгөөр өсөж оны эцэст 49.4 сая төгрөгийн авлага тайлагнасны 46.0 сая төгрөг нь Шүүхийн шийдвэрээр олгосон цалингийн нөхөн олговрын, 0.1 сая төгрөг нь татварын, 3.3 сая төгрөг нь хувь хүмүүсээс авах авлага байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 28.0 сая төгрөг болж 21.6 сая төгрөгөөр өссөн нь аж ахуйн материалын үлдэгдэл өссөнтэй холбоотой. Тайлант хугацаанд төсвийн хөрөнгөөр 107.0 сая төгрөгийн бараа материал бэлтгэж, үйл ажиллагаандаа 85.4 сая төгрөгийн материалыг зарцуулан оны эцэст 28.0 сая төгрөгийн бараа материалын үлдэгдэлтэй байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 257.9 сая төгрөг болж 7.7 сая төгрөгөөр өссөн. Төсвийн хөрөнгөөр 30.7 сая төгрөгийн хөрөнгө бэлтгэн, 1.5 сая төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүй хүлээн авчээ. Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2021 оны шийдвэрээр 24.5 сая төгрөгийн хөрөнгийг шилжүүлэн тайлант оны эцэст 257.9 сая төгрөгийн үндсэн хөрөнгийн үлдэгдэлтэй байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 200.6 сая төгрөг болж 29.3 сая төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ. Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн рүү хаасан бичилт хийгдээгүй. Тайлант оны хуримтлагдсан үр дүнгийн эцсийн үлдэгдэл 75.8 сая төгрөг болсон байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 491.1 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсөв захирагчид хүргүүлсэн төсвийн төслөөс 444.3 сая төгрөгөөр өсгөн 935.4 сая төгрөгөөр баталжээ.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсөв захирагчийн 1 хөтөлбөрийн хүрээнд 3 арга хэмжээг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр 935.4 сая төгрөгийн төсөв баталсан байна.

Үндсэн дансанд орон нутгийн төсвөөс 935.4 сая төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 837.0 сая төгрөгийг зарцуулж 98.4 сая төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 837.0 сая төгрөг буюу 89 хувьтай байгаа нь цалин хөлс болон нэмэгдэл урамшлын зардлыг 17.6 сая төгрөгөөр, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийг 3.9 сая төгрөгөөр, хангамж бараа материалын зардлыг 0.6 сая төгрөгөөр, эд хогшил урсгал засварын зардлыг 50.9 сая төгрөгөөр, томилолт зочны зардлыг 1.1 сая төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардлыг 24.0 сая төгрөгөөр тус тус хэмнэж зарцуулсантай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар нийт 153.3 сая төгрөгийн орлого орсноос цагаатгалын нөхөн төлбөрт 121.0 сая төгрөгийн, Дэлхийн байгаль хамгаалах сангаас 16.1 сая төгрөг, Хууль зүйн сайдын багцаас хамтарсан багийн санхүүжилт 9.0 сая төгрөг, нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагыг бэхжүүлэх сургалтын зардалд 7.2 сая төгрөгийн орлого орж зарцуулагдсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тодорхой бус байдал үүссэн, хэрэглэгчдэд хамааралтай санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудалгүй.

3.8 Аудитын гол асуудал

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудал байхгүй.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасны дагуу Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны Шилэн дансны хуулийн хэрэгжилт, и-баримтын бүрдлийг хяналаа.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд Шилэн дансны цахим хуудсанд оруулбал зохих 46 мэдээллээс цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 18 төрлийн 1,054.5 сая төгрөгийн орлогын мөнгөн гүйлгээ, 8 төрлийн 448.7 сая төгрөгийн зарлагын мөнгөн гүйлгээ, 12 төрлийн 49.5 сая төгрөгийн авлагын шийдвэр, 1 төрлийн 41.3 сая төгрөгийн тендерийн ерөнхий мэдээллийг байршуулаагүй байна. Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн Шилэн дансны цахим хуудсанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

3.9.2 И-баримттай холбоотой

Тус байгууллага нь тайлант онд аж ахуйн нэгж, байгууллагаас худалдан авалт хийхдээ И-баримтгүй 12.4 сая төгрөгийн гүйлгээ хийснээс аудитын явцад 6.7 сая төгрөгийн төлбөрийн баримтыг нөхөн шивүүлсэн.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.2-т заасан заалттай нийцэхгүй байна.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь 2019 оны санхүүгийн тайлангийн аудитын шийдвэрээс 29.4 сая төгрөгийн актыг барагдуулаагүй байна.

2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар 0.3 сая төгрөгийн төлбөрийн акт, 119.5 сая төгрөгийн зөрчил арилгуулах албан шаардлага, 0.5 сая төгрөгийн зөвлөмж хүргүүлснийг хэрэгжүүлж ажиллажээ. Гэвч үүнээс 30.9 сая төгрөгийн авлагатай холбоотой албан шаардлагыг хэрэгжүүлээгүй байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар өглөг, авлагын бүртгэл, аудитаар өгсөн шийдвэрийн хэрэгжилтийг үзэх нь зүйтэй. Шүүхийн шийдвэрээр олгосон цалин олговортой холбоотой төсөвт үүссэн хохирлыг хэрхэн барагдуулах ажил зохион байгуулсан талаар үзэх хэрэгтэй.

Мөн Төрийн албаны тухай хууль тогтоомж зөрчиж томилсон Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ажлын албаны төрийн захиргааны 4 албан хаагч байгааг Төрийн албаны зөвлөлийн шийдвэрт тусгажээ. Энэ зөрчлийг хэрхэн арилгасан талаар дараагийн аудитаар үзэх нь зүйтэй юм.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 70.8 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 43.8 сая төгрөгийн алдааг залруулж, 27.0 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлээ.

4.1 Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай холбоотой 34.3 сая төгрөгийн залруулга хийгдсэн. Иргэн аж ахуйн нэгж байгууллагаас худалдан авалтын 6.7 сая төгрөгийн и баримтыг нөхөн шивүүлсэн.

Мөн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл, хамтарсан багуудын туршлага судлах үйл ажиллагаанд 2.3 сая төгрөгийн шатахууны зарцуулаагүй, талоны үлдэгдэлтэй байгаа боловч шууд зардлаар тайлагнасныг залруулж үнэ төлбөргүй орлого авхуулсан. Илүү олгосон 0.5 сая төгрөгийн цалинг төлүүлээ.

4.2 Төлбөрийн акт

Төлбөрийн акт тогтоогоогүй.

4.3 Албан шаардлага

Удирдлагын буруутай шийдвэрийн улмаас цалингийн нөхөн олговорт 16.4 сая төгрөгийг төлж төсөв хохироосон нь Захиргааны ерөнхий хуулийн 103.1-т "Иргэн, хуулийн этгээдийн хохирлыг барагдуулсны улмаас өөрт учирсан хохирлыг захиргааны байгууллага Иргэний хуулийн 498.5-д заасны дагуу гэм буруутай албан тушаалтнаар буцааж төлүүлнэ.", Хөдөлмөрийн тухай хуулийн 132.1-т "Хөдөлмөрлөх үүргээ биелүүлэх явцдаа өөрийн буруугаас байгууллагад эд хөрөнгийн хохирол учруулсан ажилтанд сахилгын, захиргааны, эрүүгийн хариуцлага оногдуулсан эсэхийг харгалзахгүйгээр эд хөрөнгийн хариуцлага хүлээлгэнэ.", Төрийн албаны тухай хуулийн 50.1-т "Төрийн жинхэнэ албан хаагчийг хууль бусаар төрийн албанаас чөлөөлсөн, түр чөлөөлсөн, халсныг төрийн албаны төв байгууллага, эсхүл шүүх тогтоосон бол төрд учруулсан хохирлыг уг шийдвэрийг гаргасан буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлнэ." заасантай нийцээгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

Санхүүгийн тайлан дахь татварын өглөг, авлага нь Татварын тодорхойлолтоос 3.9 сая төгрөгөөр зөрүүтэй нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-т "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", 20.2.6-т "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;" гэж заасантай нийцээгүй, оршин байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

Ажилчдын цалингаас Нийгмийн даатгалд 0.6 сая төгрөгийн цалинг илүү тайлагнасан нь Нийгмийн даатгалын тухай хуулийн 17 дугаар зүйл, 16.1-т "Ажил олгогч нь даатгуулагчийн төлбөр зохих нийгмийн даатгалын шимтгэлийг түүнд хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлого олгох бүртээ энэ хуулийн 15 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан хувь хэмжээгээр тооцон суутгаж, тухайн сард нь багтаан нийгмийн даатгалын санд шилжүүлнэ" гэж заасантай нийцээгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

Шатахууны зардлаас 0.4 сая төгрөгийн шатахууны зарцуулалтын тайлангүй, жолоочийн тооцоо бодолгүйгээр шууд зардлаар тайлагнасан. Жолоочийн тооцооны хуудсанд спидометрийн заалт зөрүүтэй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.7-т "тогтоосон журмын дагуу анхан шатны бүртгэлийг хөтөлж нягтлан бодох

бүртгэлийн тайлан тэнцэл, статистикийн мэдээ гаргах ажлыг зохион байгуулж, тэдгээрийн үнэн зөвийг хариуцах" гэж заасантай нийцээгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

Аж ахуйн нэгж, байгууллагаас 5.7 сая төгрөгийн и-баримтгүй худалдан авалт хийсэн нь Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.2-т "Татвар төлөгч ногдуулалт хийхдээ энэ хуульд заасан нийтлэг журмыг баримтлах бөгөөд холбогдох хуульд заасны дагуу орлого, зарлагын гүйлгээг бүртгэх, баримтжуулах, цахим төлбөрийн баримт үйлдэх, хэвлэх, илгээх, татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд мэдээлэл дамжуулах зориулалт бүхий, нэгдсэн системд холбогдсон, стандартын шаардлага хангасан кассын машин, төхөөрөмж, компьютер, бусад дагалдах хэрэгслийг зориулалтын дагуу бүрэн ашиглаж, борлуулалтын мэдээллийг 14 хоногт багтаан татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд илгээж, бүртгүүлнэ.", Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3-т "Албан татвар суутган төлөгч хоорондын бараа борлуулсан, ажил гүйцэтгэсэн, үйлчилгээ үзүүлсэн тухай бүрд төлбөрийн баримт олгох бөгөөд уг баримтуудыг дангаар, эсхүл хамтатган нэмэгдсэн өртгийн албан татварын падаан үйлдэнэ" гэж заасныг зөрчиж, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

Шилэн дансны цахим хуудсанд оруулбал зохих 46 мэдээллээс цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 18 төрлийн 1,054.5 сая төгрөгийн орлогын мөнгөн гүйлгээ, 8 төрлийн 448.7 сая төгрөгийн зарлагын мөнгөн гүйлгээ, 12 төрлийн 49.5 сая төгрөгийн авлагын шийдвэр, 1 төрлийн 41.3 сая төгрөгийн тендерийн ерөнхий мэдээллийг байршуулаагүй нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4-т "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ:, 6.4.4.таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг;, 6.4.5.цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр; 6.4.8.бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс,төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр" гэж заасантай нийцээгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

4.4 Зөвлөмж

Аудитаар зөвлөмж өгөөгүй.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

1. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

№	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Говь-Алтай аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал	7	70.8	1	43.8	0	0	6	27.0		

/сая төгрөг/